



**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2015 оны 08 сарын 25 өдөр

Дугаар А/234


Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.5.8.3 дахь заалт, МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 04 тоот Тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэж дэмжигдсэн "Монгол Улсын Их Сургуульд зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Монгол Улсын Их Сургуулийн Хүндэт цол олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2015 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. "Монгол Улсын Их Сургуульд зөвлөх, гэрээт ба зочин профессор, цагийн багш ажиллуулах журам", "Монгол Улсын Их Сургуулийн Хүндэт цол олгох журам"-ыг чанд мөрдөн ажиллахыг бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирал /Ж.Эрдэнэбулган, Н.Батнасан, С.Баттулга, Н.Баатарбилэг, Б.Баяртогтох, Д.Намжил, Н.Эрдэнэчимэг/ нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хяналт шинжилгээ үнэлгээний албаны дарга /В.Батцэнгэл/-д даалгасугай.

ЗАХИРАЛ



Р.БАТ-ЭРДЭНЭ

МУИС-ийн захирлын 2015 оны ...-р сарын...-ны
эдрийн ... дугаар тушаалын 2 дугаар хавсралт



МУИС-ИЙН ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ ЖУРАМ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

МУИС-ийн Эрдмийн Зөвлөлөөс МУИС-ийн хүндэт цол олгоход уг журмыг дагаж мөрдөнө.

МУИС-ийн хүндэт цол нь МУИС-ийн, Бүрэлдэхүүн сургуулийн гэсэн хоёр төрөл байна.

НЭГ. МУИС-ИЙН ХҮНДЭТ ЦОЛ

- 1.1 МУИС-ийн хүндэт цол нь "Хүндэт доктор", "Хүндэт профессор", "Эмерит профессор" байна.
- 1.2 Хүндэт доктор цолыг шинжлэх ухаан, соёл, боловсролыг хөгжүүлэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан эрдэмтэн, энх тайван, хүмүүнлэг, төр, олон нийтийн салбарын нэрт зүтгэлтэн гадаадын иргэнд,
- 1.3 Хүндэт профессор цолыг МУИС-ийн хөгжил, дэвшилд оруулсан гавьяа зүтгэл, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлын техник технологийн шинэчлэлд оруулсан үнэтэй хувь нэмэр зэргийг үнэлж, гадаадын эрдэмтэнд,
- 1.4 Эмерит профессор цолыг МУИС-д ажиллах хөдөлмөрийн гэрээ нь дуусгавар болсон, журамд заасан шаардлагыг хангасан зөвлөх профессор тус тус олгоно.

ХОЁР. БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ЦОЛ

- 2.1. Бүрэлдэхүүний сургуулийн хүндэт цол нь салбарын "Хүндэт доктор" байна.
- 2.2. Бүрэлдэхүүний сургуулийн хүндэт доктор цолыг шинжлэх ухааны тухайн салбарт эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажлын техник технологийн шинэчлэлд жинтэй хувь нэмэр оруулсан, өөрийн шавь сургалт, дэг сургуулийг буй болгосон, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх үйлсэд асар их үүрэг гүйцэтгэсэн эрдэмтэн, төр, нийгэм, олон нийтийн байгууллагын зүтгэлтэн, дэмжигч дотоод, гадаадын иргэнд олгоно.

ГУРАВ. ЭМЕРИТ ПРОФЕССОР

- 3.1. МУИС-ийн профессор, дэд профессор цолтой, тус сургуульд 20-аас доошгүй жил профессорын албан тушаалд ажилласан, шинжлэх ухаан, боловсролыг хөгжүүлэх үйлсэд дорвитой хувь нэмэр оруулсан эрдэмтэнд Эмерит профессор цол олгоно.
- 3.2. Эмерит профессор нь МУИС-ийн хөгжилд хувь нэмэр оруулах, гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, МУИС-ийн нэр хүнд, нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэхэд зохих хүчин чармайлт гарган ажиллах үүрэг хүлээнэ.

- 135
- 3.3. Эмерит профессор нь МУИС-ийн дэд бүтцийг ашиглан эрдэм шинжилгээний бие даасан санхүүжилттэй дотоод, гадаадын төсөл хэрэгжүүлэхэд ямар нэгэн хязгаарлалт тогтоохгүй бөгөөд гадаадад эрдэм шинжилгээний хуралд оролцоход санхүүгийн зохих дэмжлэг авах, сургууль, тэнхимийн саналаар ажлын хэсэг, шалгалтын комисс, зөвлөх багт ажиллах, шаардлагатай бусад үйл ажиллагаанд оролцох, хоёр жилд нэг удаа мөнгөн тусламж авах, мөн түүнчлэн сургуулийн ёслол, хүндэтгэлийн арга хэмжээнд уригдах эрхтэй.

ДӨРӨВ. ХҮНДЭТ ЦОЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 4.1. Хүндэт цолд нэр дэвшигчийн үндсэн харьяа байгууллагын албан тодорхойлолт, танилцуулга
- 4.2. Хүндэт цолд нэр дэвшигчийн бүтээлийн жагсаалт, гол бүтээлүүд, тэдгээрийн товч танилцуулга
- 4.3. Хүндэт цолд нэр дэвшүүлэгч байгууллага, харьяалах бүрэлдэхүүн факультет, сургуулийн эрдмийн зөвлөлийн болон тэнхимийн хурлын тэмдэглэл, шийдвэр
- 4.4. Хүндэт цолд нэр дэвшигчийн эрдмийн зэрэг, цолыг баталсан албан ёсны үнэмлэх, диплом, тэдгээрийн баталгаат хуулбар
- 4.5. Эмерит профессор цолд нэр дэвшигчийг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөл хэлэлцэн шийдвэр гаргаж, улмаар МУИС-ийн Эрдмийн зөвлөлд уламжилна.

ТАВ. ХҮНДЭТ ЦОЛ ОЛГОХ

- 5.1. МУИС-ийн хүндэт доктор, хүндэт профессор цол, эмерит профессор олгох эсэхийг МУИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар, салбарын хүндэт доктор цолыг бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 5.2. МУИС-ийн "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол хүртсэн иргэнд үнэмлэх, зүүлт гардуулж, өмсгөл өмсгөнө. "Эмерит профессор" цол хүртсэн иргэнд энгэрийн тэмдэг, диплом гардуулна. Хүндэт цол хүртэгсдэд МУИС-ийн үнэмлэх олгоно.
- 5.3. Бүрэлдэхүүн сургуулийн хүндэт доктор цол хүртсэн иргэнд үнэмлэх, МУИС-ийн хүндэт медаль гардуулна.
- 5.4. Хүндэт цол хүртсэн иргэнд олгох батламжийг (үнэмлэх, диплом, зүүлт, өмсгөл, хүндэт медаль) тус тусын Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар албан ёсоор, гүн хүндэтгэлтэйгээр гардуулна.
- 5.5. МУИС-ийн Хүндэт цол хүртэгсэд Эрдмийн дугуй тэнхимд эрдэмтэн багш, судлаач, суралцагчдад зориулан лекц уншина.
- 5.6. Хүндэт цол хүртсэн иргэн МУИС-ийн хүндэтгэл хүлээнэ.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1. Өмнөх журмаар МУИС-ийн хүндэт, профессор цол хүртэгсдэд шинэчилсэн журмын заалт хамаарахгүй.